

КОМПАНИЙН  
НИЙГМИЙН  
ХАРИУЦЛАГА  
ГЭЖ ЮУ ВЭ?







Konrad  
Adenauer  
Stiftung

# КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

- ГАРЫН АВЛАГА -

Улаанбаатар хот 2017 он





“НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН САНААЧЛАГА” ТББ

Корпорэйт хотел, Конвешн Центр

Хан-Уул дүүрэг, Махатма Гандийн гудамж- 39

Утас/Факс: 976-70107677, 99109718

Email: srimongolia@gmail.com

<https://www.facebook.com/srimongolia/>

**Зохиогч:**

**Л.Өнөр**

**Ч.Нэргүй**

**Зөвлөх:**

**С.Дэмбэрэл**

**Редактор:**

**Т.Тэгшбаяр**

**Гэрэл зургийг:**

**П.Чимэдням**

**Дизайнер:**

**Ц.Пүрэвдорж /PujiPress/**

© Хуулбарлахыг хориглоно  
Зохиогчийн бүх эрх хуулиар  
хамгаалагдсан.



## ӨМНӨХ ҮГ

Энэхүү гарын авлагаар дамжуулан бизнес эрхлэгчид нийгмийн өмнө хүлээх үүрэг хариуцлагаа хэрхэн хэрэгжүүлэх талаар сэдэл, түлхэц өгөх мөн цаашид хөгжлийн гурван тулгуур болох эдийн засаг, нийгэм, хүрээлэн буй орчиндоо ээлтэй ашгийн төлөө үйл ажиллагаа явуулах замаар илүү өрсөлдөх чадвартай, тогтвортой компаниудыг Монгол улсад өсөн нэмэгдэхэд хувь нэмэр оруулахыг зорилоо.

Өнөөдөр олж байгаа амжилтаа тогтвортой хадгалах, нийгэмдээ хүлээн зөвшөөрөгдөх нь аль ч салбарын бизнесийн зорилго гэдэг нь тодорхой. Бизнесийн тогтвортой байдал, нийгмийн сэтгэл ханамж хоёр хоорондоо салшгүй холбоотой өөрөөр хэлбэл харилцан уялдаатай нэг нь нөгөөгүйгээрээ хөгжиж, амжилтанд хүрч чадахгүй гэдгийг бид мартаж болохгүй. Тиймээс компаниуд нийгмийн өмнө хүлээсэн хариуцлагаа бүрэн ухамсарлаж, үйл ажиллагаагаа зөв тийш нь залж чиглүүлснээр зөвхөн дан ганц өөрсөддөө биш, нийгэмдээ ашиг тусаа өгөхөөс гадна дэлхийн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулж буй явдал юм.

Монголын компани, аж ахуйн нэгжүүдийг зөвхөн санхүүгийн ашиг орлогын төлөө ажилладаг бус, байгаль орчин, нийгэмд ээлтэй хариуцлагатай үйл ажиллагаа явуулдаг болоход уриалж, тэдгээрийг мэдлэг мэдээллээр хангах санаачлага гарган манлайлж ажиллаж байгаа “Конрад Аденауэр”-ын Сангийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газарт талархал илэрхийлье.

Том компаниудад л, эсвэл уул уурхайд л хамаатай гэж төвөгшөөлгүйгээр, бизнесийн чиглэлийн олон номны нэг байна хэмээж хойш тавилгүйгээр таны бизнестэй хэрхэн уялдаж болох талаар сайтар уншиж, таньж мэдэж, хамтдаа хөгжихийг хүсье.





# АГУУЛГА

---

1. КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ТУХАЙ ТОДОРХОЙЛОЛТ, ҮҮСЭЛ ХӨГЖИЛ, ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ, ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ
2. КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ШААРДЛАГУУД, ХҮРЭХ БОЛОМЖИТ ҮР ДҮНГҮҮД
3. КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛ, ХЭРЭГЖҮҮЛЭХЭД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛС, БАРИМТЛАХ ЗҮЙЛС
4. КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ХАМТРАГЧДЫН ОРОЛЦОО, ХӨДӨЛГӨГЧ ГОЛ ХҮЧИН ЗҮЙЛС
5. КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ, ТАНИУЛАН СУРТАЛЧЛАХ НЬ
6. КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА, БИЗНЕСИЙН УДИРДЛАГЫН ШИНЭ ХАНДЛАГА БОЛОХ НЬ
7. НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ОЛОН УЛСЫН ISO -26000 СТАНДАРТ
8. КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙСАН ТУРШЛАГА
9. КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ТАЛААРХ ЗАРИМ НЭГ ТАШАА ОЙЛГОЛТУУД



1

КОМПАНИЙН НИЙГМИЙН  
ХАРИУЦЛАГЫН ТОДОРХОЙЛОЛТ,  
ҮҮСЭЛ ХӨГЖИЛ, ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ,  
ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ





## КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА /КНХ/ ТОДОРХОЙЛОЛТ

**К**НХ гэдэг нь аливаа аж ахуйн нэгж өөрийн үйл ажиллагаагаа хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, байгаль орчинд бохирдолгүй, нийгэмд сөрөг үр дагаваргүй илтөд, нээлттэй явуулна гэсэн ойлголт болно. Хамтрагч, түншүүд, олон нийт, хэрэглэгч, ажиллагсдынхаа өмнө хүлээх хариуцлага, чиг хандлагаа тодорхойлсон хэм хэмжээг бизнесийн үйл ажиллагаандаа баримтлан ажиллах замаар байгууллагадаа баялгийг бүтээн бий болгох төдийгүй улс орны нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад хувь нэмрээ оруулах үйл явц юм.



# КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ҮҮСЭЛ ХӨГЖИЛ

**Н**эрт эдийн засагч Адам Смит “Бизнес эдийн засгийн сонгодог загвар”-ыг боловсруулсан бөгөөд зах зээлд оролцогч хувь хүн, байгууллагууд хэдийгээр ашгийн төлөө бизнес эрхэлж байгаа ч нөгөө талаар бусдын хэрэгцээ шаардлагыг хангадаг тул энэ нь нийгэмд үйлчилж буй явдал хэмээн үзсэн байдаг.

XIX зууны аж үйлдвэрийн хувьсгалын үед үйлдвэрлэлд ахиц гарч шинэ техник технологи нэвтрэн олон сая хүн ажилтай болж ахуй амьдрал нь сайжирч ирснээр нийгмийн баялаг цөөн хүмүүсийн гарт хуримтлагдаж хөрөнгөтөн анги үүсч хөгжсөн бөгөөд тэдний ихэнх нь “Социал дарвинизм” буюу байгалийн шалгарлын зарчмыг бизнес, нийгэмд нэвтрүүлсэн ба энэ үеийг “Зэрлэг капитализмын үе” хэмээн нэрлэдэг. XX зууны эхэн үед бизнесийнхэн томорч өргөжин хүчирхэгжиж ирсэн

бөгөөд үүнтэй уялдан тэднийг нийгмийн эсрэг, өрсөлдөөний эсрэг үйл ажиллагаа явуулж байна хэмээн шүүмжилцгээх болсон ба ажилчдыг, нийгмийг, орон нутгийг тэднээс хамгаалах, нэн ялангуяа ажилчин ангийг хамгаалах чиглэлээр олон хөдөлгөөн, тэмцэл өрнөсөн.

1900-1960 оны хооронд бизнесийнхэн хууль журмыг биелүүлэх, ашиг хийхээс гадна нийгмийн талаар нэмэлт үүрэг хүлээх ёстой юм байна гэдгийг ойлгон ухамсарлаж хэрэгжүүлж эхлэх болсон.

1960-70-аад оны үед иргэний хөдөлгөөнүүд, байгаль орчныг хамгаалагчид, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалагчид гээд олон бүлэг, хөдөлгөөнүүд гарч ирэн бизнесийн салбарт нийгмийн хариуцлагыг хүчтэй тавих болсноор КНХ дэлгэрч, аажимдаа бизнесийнхэн сайн дураар хэрэгжүүлэх болсон.





## КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ТУХАЙ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ, ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

**Н**обелийн шагналт, эдийн засагч Милтон Фридман “Бизнесийн нийгмийн хариуцлага бол ашгаа нэмэгдүүлэх явдал” хэмээн бичсэн байдаг. Өөрөөр хэлбэл “Бизнесийн бизнес бол бизнес өөрөө юм” гэсэн үзэл давамгайлж ирсэн. Тухайн компаний хувьцаа эзэмшигчдийн ашиг орлогыг нэмэгдүүлэх нь бизнесийн нийгмийн хариуцлага байх ёстой гэсэн энэхүү өвөрмөц санаа нь зөвхөн хувьцаа эзэмшигчдээр хязгаарлагдаагүй бөгөөд хамтрагч бүхий л талыг буюу Эдвард Фридманы тодорхойлсноор “Хамтрагчид” болох тухайн байгууллагын зорилтыг хэрэгжүүлэхэд оролцож, нөлөөлж буй хэрэглэгчид, ажиллагсад, орон нутаг, байгаль орчин, нийгэм бүхлээрээ энэ ойлголтод хамрагдаж байгаа юм.

Энэхүү үзэл санаанаас КНХ /

Corporate Social Responsibility/-ын талаарх ойлголт, үзэл санаа үүсч бий болсон бөгөөд буяны өглөг хандиваас эхлээд хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулах, нийгэм, байгаль орчин, ёс зүйн асуудлуудыг шийдэхэд бизнесийн байгууллагуудын хүлээх үүрэг хариуцлагаар дамжин тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд хүрсэн. Ийнхүү энэ олон талын итгэл үнэмшил, хүлээлт, ашиг сонирхлыг нэг цэгт төвлөрүүлэн нэгтгэж байдаг хүчин зүйл нь КНХ бөгөөд сүүлийн жилүүдэд дэлхий дахинд энэ асуудалд ихээхэн анхаарч байна.

Монгол улсын хувьд КНХ-ийн талаарх ойлголт сүүлийн хэдэн жилд тодорхой хэмжээнд яригдаж, хэрэгжиж эхэлж байгаа ч бизнесийн нийт хүрээнийхнийг бүрэн хамарч, хүрч чадаагүй байна.





# 2

КОМПАНИЙН НИЙГМИЙН  
ХАРИУЦЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ  
ШААРДЛАГУУД,  
ХҮРЭХ БОЛОМЖИТ ҮР ДҮНГҮҮД









## КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ШААРДЛАГУУД

- Өрсөлдөх чадвар, хөрөнгө оруулалт нэмэгдүүлэх
- Компанийн нэр хүнд нийгэмд өсөн нэмэгдэх
- Тогтвортой, чадварлаг, үнэнч боловсон хүчнийг татах
- Технологиор тэргүүлэх, тасралтгүй сайжруулалт бий болох
- Санхүүгийн үзүүлэлтийг сайжруулах
- Тогтмол борлуулалт, нийлүүлэлтийн сувгийг бий болгох
- Өөрчлөлт, шинэчлэлийг хэрэгжүүлэх
- Нийгэмд хүлээн зөвшөөрөгдөх
- Баялгийг бүтээн бий болгох
- Төрийн байгууллагуудтай харилцах харилцаа сайжруулах
- Тогтвортой хэрэглээг дэмжих

## КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ХҮРЭХ БОЛОМЖИТ ҮР ДҮНГҮҮД

**К**НХ нь зөвхөн зөв зүйлийг, тэр дундаа буяны эсвэл хандивын ажил хийнэ гэсэн үг биш бөгөөд харин ч бизнесийн үр ашигт шууд чиглэгддэг. (Милтон Фридман) Бизнесийнхээ нэр хүндийг өндөрт өргөх үйл явцаар дамжуулан хэрэглэгчээ татах, хадгалж үлдэх, олон нийтэд зөвөөр ойлгогдож хүлээн зөвшөөрөгдөх нь хариуцлагатай бизнесийн чухал шинж юм. Олонхи хэрэглэгчид ёс зүйтэй бизнесээс буюу үйлдвэрлэгч, нийлүүлэгчээс бараа бүтээгдэхүүн худалдаж авахыг илүүтэй хүсдэг. Хог хаягдлыг багасгаж, агаарын бохирдлыг бууруулах нь зөвхөн байгаль орчинд тустай төдий асуудал биш бөгөөд бизнес эрхлэгчийн хувьд ч гэсэн хөрөнгө мөнгө хэмнэх боломжийг олгодог. КНХ нь дараах үр ашгуудыг шууд болон шууд бусаар авчирдаг.



Н бүтээл

ХҮРЭМ ОЁХ АРГАЧЛАЛ

АНЦУЙНЫ ЗАГВАР

ХӨСӨНМӨР ХАМГААЛАЛ АЮУЛГУЙ  
АЖИЛЛАГААНЫ САМБАР

ТАНЫ АЖУУ



## **ӨРСӨЛДӨХ ЧАДВАР, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ НЭМЭГДҮҮЛНЭ**

КНХ нь тухайн компанийг өрсөлдөх чадвартай болгодог бөгөөд хөрөнгө оруулагчдын зүгээс санхүүжилт хийх хүсэл сонирхлыг илүү төрүүлдэг. Зах зээлийн орчин нөхцөлтэй холбоотойгоор улам бүр өсөн нэмэгдэж буй хууль эрх зүй, нийгэм, байгаль орчин, эдийн засаг болон бусад олон эрсдэлүүдийг үр дүнтэй удирдан зохицуулах нь нийт зах зээлийн тогтвортой байдлыг хангахад чухал үүрэгтэй байдаг.

## **КОМПАНИЙН НЭР ХҮНД НИЙГЭМД ӨСӨН НЭМЭГДЭНЭ**

КНХ-ыг сайн хэрэгжүүлж буй компанийн нийгэмд эзлэх байр суурь, нэр хүнд өсөн нэмэгддэг. Тухайн компанийн нэр хүнд, байр суурь нэмэгдэх нь тухайн компанийн найдвартай байдал, төлбөрийн чадвар, бүтээгдэхүүн үйлчилгээний чанар гээд олон хүчин зүйлээс хамаардаг.

## **ТОГТВОРТОЙ, ЧАДВАРЛАГ, ҮНЭНЧ АЖИЛТНЫГ ТАТНА**

Тухайн байгууллагын бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр хүнд, нөхцөл байдалд шууд нөлөө үзүүлдэг нэг хүчин зүйл бол хүний нөөцийн бодлого, үйл ажиллагааг сайжруулах явдал бөгөөд энэ нь тухайн КНХ-ын нэг салшгүй хэсэг болдог. Боловсон хүчнээ сургаж бэлтгэн чадавхижуулах нь ажиллагсадынхаа зан суртахуун, ёс заншил, үнэнч шударга байдалд шууд нөлөө үзүүлдэг. Ажиллагсад нь тухайн байгууллагын үйл ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх тэргүүлэгч эх үүсвэр болохоос гадна тухайн байгууллагын бахархал нь байдаг.





### **ТЕХНОЛОГИОР ТЭРГҮҮЛЭХ, ТАСРАЛТГҮЙ САЙЖРУУЛАЛТ БИЙ БОЛНО**

Инноваци, өрсөлдөх чадвар бол зах зээл дэх байр суурийг нэмэгдүүлнэ. Хамтрагч, оролцогчдын зүгээс тавих шаардлага, хэрэгцээ нь компанийн хувьд шинэ шинэ бараа бүтээгдэхүүн бий болгох, шинэ зах зээл, шинэ процесс, үйл ажиллагааг бий болгохыг зайлшгүй шаарддаг бөгөөд энэ нь тухайн компанид өрсөлдөөнд давуу тал олж авахад нь тусалдаг. Компани нь байгаль орчны болоод нийгмийн тодорхой стандартуудыг хэрэгжүүлснээр нийлүүлэлтээ нэмэгдүүлэх боломжийг олдог ба сайн бизнесийн түүхээс үзэхэд инноваци нэвтрүүлсэн, зах зээлд чиглэгдсэн, чиг хандлагаа зөв тодорхойлж чадсан компани амжилт олж чаддаг байна.


### **САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙГ САЙЖРУУЛНА**

Үр ашигтай КНХ нь зардлыг багасгаж худалдааг өргөжүүлэх явдлаар илэрдэг. Зардал хэмнэж үйл ажиллагааны ашиг орлого нэмэгдэнэ. Компанийхаа үр ашгийг нэмэгдүүлэх, менежментийн тогтвортой чиг хандлага нь КНХ-ыг үр дүнтэй хэрэгжүүлснээр тодорхой хэмжээнд хангагддаг. Тухайлбал байгаль орчин, эрчим хүчний асуудлыг үйл ажиллагаандаа баримтлан хэрэгжүүлснээр хаягдлыг орлого болгох боломж бүрддэг.

### **НИЙЛҮҮЛЭЛТИЙН ГИНЖИН СУВАГ БИЙ БОЛГОНО**

Аливаа компанийн хувьд өөрийн бараа бүтээгдэхүүнээ түгээх, борлуулах сувгуудыг бий болгохын тулд бүтээгдэхүүнийхээ чанарыг дээшлүүлэх замаар урт хугацааны үр ашигтай харилцаа тогтоож эрсдэлээ бууруулж чаддаг. Томоохон компаниудын хувьд хамтрагч жижиг компаниудынхаа КНХ-ыг хэрэгжүүлэх, эрчимжүүлэхэд тодорхой үүрэг хүлээдэг. Тухайлбал жижиглэн худалдааны томоохон компанийн хувьд өөрийн нийлүүлэгчдэд хөдөлмөрийн ёс зүйн зарчим, стандартуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэхийг шаардах замаар тэдний КНХ-ыг сайжруулахад чухал үүрэг гүйцэтгэдэг.





### **ӨӨРЧЛӨЛТ, ШИНЭЧЛЭЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛНЭ**

Өөрийн бизнесийн үйл ажиллагаатай хамааралтай бүхий л түншүүд, хамтрагч, ороолцогчидтойгоо байнгын харилцаатай байж хамтран ажилладаг “дуулгавартай” компанийн хувьд эдийн засаг, нийгэм, байгаль орчны өөрчлөлт, шинэчлэлд хөл алдахгүй, харин ч баттай байр суурь эзэлж чаддаг. Өөрөөр хэлбэл компаниуд нь КНХ-ыг хэрэгжүүлснээр зах зээл дэх өөрчлөлтийн чиг хандлагыг таамаглах, амжилттай хэрэгжүүлэх нүд, чих нь болдог.

### **НИЙГЭМД ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨГДӨНӨ**

Тухайн компанийн зорилго, үйл ажиллагааны талаарх иргэд, оролцогчдын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлснээр тэдэнтэй тогтоох харилцаа холбоо улам бүр бэхждэг. Энэ нь эргээд нийгэм, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын итгэл найдварыг олж авахад нөлөөлдөг. КНХ нь нийгмийн капиталыг бий болгоход тусалдаг нэг гол хэрэгсэл юм.



### **БАЯЛГИЙГ БҮТЭЭН БИЙ БОЛГОНО**

Санхүүгийн байгууллагууд компаниудын нийгэм, байгаль орчны шалгуур үзүүлэлтүүдийг өөрсдийн үйл ажиллагаа, бодлого шийдвэр гаргах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхдээ өргөн ашигладаг. Хөрөнгө оруулагчдын хувьд хөрөнгө мөнгөө КНХ-ын үр дүнтэй, өгөөжтэй менежмент бүхий компанид оруулах сонирхол өндөр байдаг. Иймээс КНХ-ийг сайн тусгаж оруулсан бизнес төлөвлөгөө, төсөл нь сайн менежментийн нэг гол хэрэгсэл хэмээн үздэг.

### **ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДАЙ ХАРИЛЦАХ ХАРИЛЦААГ САЙЖРУУЛНА**

Үйлчилж буй хууль тогтоомжийн хүрээнд, авч хэрэгжүүлж буй зохицуулалтын дагуу үйл ажиллагаагаа явуулахыг аж ахуйн нэгжүүдээс Засгийн газар, хууль тогтоогчид шаарддаг. Зарим улс орнуудад экспортын гэрээ хэлцэл байгуулах, гадаад худалдаа эрхлэх компаниудад КНХ-ын үзүүлэлтүүдийг хэрхэн хэрэгжүүлж буйг нь харгалзан үзэж зөвшөөрөл лиценз олгодог практик ч байдаг. Засгийн газар нь бизнесийн үйл ажиллагаанд оролцох оролцоогоо багасгах замаар экспорт, гадаад худалдааныхаа зорилтыг хангахад КНХ-ыг нэг гол хэрэгслээ болгодог.

### **ТОГТВОРТОЙ ХЭРЭГЛЭЭГ ДЭМЖИНЭ**

Тогтвортой хөгжлийг хангах чухал хүчин зүйл нь тогтвортой хэрэглээ юм. Нийгмийг шаардагдаж буй бараа бүтээгдэхүүн, үйлчилгээгээр хангах, нийлүүлэхарга замыг бий болгох замаар тогтвортой хэрэглээг бий болгоход компаниуд чухал үүрэг гүйцэтгэдэг. “Хариуцлагатай хэрэглээ” гэдэг бол зөвхөн хэрэглэгчдийг дээдэлнэ гэсэн ойлголт биш бөгөөд зах зээлд ямар бараа бүтээгдэхүүн нийлүүлж байна, тэдгээр нь хэрэглэгчдийн эрх ашиг, тогтвортой хэрэглээг хэрхэн хангаж байна, хэрэглэгч-үйлдвэрлэгч хоёрын хоорондын харилцааг бодлого боловсруулагчид хэрхэн зохицуулж байна гэдгээр тодорхойлогддог.







# 3

КОМПАНИЙН НИЙГМИЙН  
ХАРИУЦЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ  
ЧИГЛЭЛ, ХЭРЭГЖҮҮЛЭХЭД  
НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛС,  
БАРИМТЛАХ ЗҮЙЛС

## КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛ

**К**НХ нь зөвхөн томоохон байгууллага, компанид хамаатай асуудал биш бөгөөд хувийн компани аж ахуйн нэгжид төдийгүй төрийн өмчит компани, улсын болон хувийн үйлдвэрийн газарт хамаарна. Харамсалтай нь ихэнх хүмүүсийн дунд жижиг дунд бизнест энэ огт хамаагүй мэтээр ойлгодог, зарим улс оронд КНХ хөгжүүлж хэрэгжүүлэх нь боломжгүй ч гэсэн үзэл байдаг. КНХ нь:

-Бизнесийн салбар

-Өмчийн хэлбэр

-Компаний хэмжээ

-Улс орны хөгжлийн хандлага зэргээс шалтгаалахгүйгээр заавал хэрэгжүүлж байх бизнесийн үйл ажиллагааны нэг салшгүй хэсэг юм.

## КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД НӨЛӨӨЛДӨГ ХҮЧИН ЗҮЙЛҮҮД

### ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

Байгалийн нөөц баялгаа зүй зохистой ашиглаж зарцуулах шаардлага хүн төрөлхтөний өмнө тулгараад байна. Өнөөгийн замбараагүй хэрэглээ нь ирээдүй хойч үеийнхэндээ юу ч үлдээхгүй нөхцөлд хүргээд байгаа бөгөөд энэ ч утгаараа өнөөгийн хөгжил тийм ч тогтвортой бус байна. Энэ байдлаар цаашдаа үргэлжлэх боломжгүй нь тодорхой. Иймээс тогтвортой хөгжлийн асуудлыг ойлгох, хэрэгжүүлэх, өөрийн бизнесийн стратеги төлөвлөгөөнд тусгах эхлэлийн цэг нь КНХ юм.





### **ДАЯАРШИЛ**

Гадаад худалдаа, үндэстэн дамнасан компаниуд, дэлхий дахины нийлүүлэлтийн сүлжээ зэрэг өсөн тэлж буй эдийн засгийн даяаршил нь хүний нөөцийн менежмент, байгаль орчны хамгаалал, эрүүл мэнд, аюулгүй байдал зэрэгт анхаарахыг шаардаж байна. Хөдөлмөрийн нөхцөл байдал, орон нутаг, эдийн засагт бизнес хэрхэн нөлөөлж байгаа, нийгмийн сайн сайхны төлөө бизнес юу хийх, ямар үе шаттайгаар хэрэгжүүлэх зэрэгт КНХ чухал үүрэг гүйцэтгэдэг. Энэ нь голчлон хөгжиж буй орнуудын экспортод чиглэгдсэн пүүс компаниудад илүү хамааралтай байдаг.

### **ЗАСАГЛАЛ**

Олон улсын байгууллагууд бизнесийн ёс зүйтэй холбоотой олон журам, тунхаглал, удирдамж, зарчмуудыг гаргадаг. КНХ-ын арга хэрэгслүүд нь ерөнхийдөө олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн зорилтууд, хүний эрх, байгаль орчинг хамгаалахад болон авилгалын эсрэг хууль журмуудыг хэрэгжүүлэхэд чиглэгддэг.



### **ХУВИЙН СЕКТОР**

Хувийн хэвшлийн тоо хэмжээ өсч байгаа засгийн газар, иргэний нийгэмтэй харьцуулахад тэдний улс төр, нийгэм, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл өсөн нэмэгдэж байгаа нь хувийн хэвшлийн нөлөө, үүрэг хариуцлагын талаарх асуудлыг улам өндөрт тавьж байна. Энд зөвхөн том компаниуд ч бус, жижиг дунд компаниудын үүрэг нөлөө ч их юм.

### **ХАРИЛЦАА ХОЛБОО**

Интернэт, үүрэн телефон гэх мэт харилцаа холбоо технологийн эрчимтэй хөгжил нь компаний үйл ажиллагааг өргөжүүлэх, хянах процессыг хялбарчилж байна. Тухайлбал менежмент, тайлагнал, өөрчлөлт шинэчлэл зэргийг хийхийг ихээхэн хялбарчилж байгаагаас гадна ТББ, хэвлэл мэдээллийнхэнд бизнесийн практик, үйл ажиллагааны талаар мэдээлэл олж авах, сурталчлахад тус дөхөм үзүүлж байна. КНХ-ын хувьд технологийн дэвшил нь хамтын ажиллагаа, яриа хэлцлийг өргөжүүлэх боломжийг олгож байгаа юм.

### **САНХҮҮ**

Хэрэглэгчид, хөрөнгө оруулагчид хариуцлагатай бизнесийг дэмжих сонирхолтой болж байна. Нийгэм, байгаль орчинтой холбоотой эрсдэлүүд, боломжуудыг компаниуд хэрхэн шийдэж буй талаарх мэдээ мэдээллийг ихээр шаардах болсон. КНХ нь хувьцааны үнэ цэнийг өсгөх, капиталын зардлыг багасгах, зах зээлд илүү тогтвортой харилцааг бий болгох зэрэгт тусалдаг.

### **БИЗНЕСИЙН ЁС ЗҮЙ**

Бизнесийн ёс зүйтэй холбоотой хэрэг зөрчил нь хувьцаа эзэмшигчид болоод ажиллагсадын итгэлийг алдагдуулах, нийгэм олон нийтийн тухайн компанид итгэх итгэлийг бууруулах зэрэг олон сөрөг үр дагавартай байдаг. КНХ нь компаний удирдлагыг сайжруулах, ил тод байдлыг бий болгох, ёс зүйн стандартыг даган мөрдөх боломжийг олгодог.







## **НИЙГМИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ**

Ихэнх улс орны иргэд компаниудыг нийгэм, байгаль орчны асуудалд өндөр анхаарал тавьж стандарт, журмуудыг хатуу даган мөрдөхийг шаарддаг. КНХ нь фирмүүдэд нийгмийн тулгамдсан асуудлуудад анхаарлаа хандуулж ажиллахыг шаарддаг.

## **МАНЛАЙЛАЛ**

Засгийн газрын хууль тогтоомж, зохицуулалтуудын хориг, хязгаарлалт нь КНХ-тай холбоотой бүхий л асуудлуудад бэрхшээл болдог. Энэ тохиолдолд КНХ нь тухайн компанийг үйл ажиллагаагаа илүү уян хатан болгох, илүү идэвхитэй ажиллахыг шаарддаг.

## **БИЗНЕСИЙН АРГА ХЭРЭГСЭЛ**

КНХ-ыг хэрэгжүүлснээр эрсдэлийг багасгаж шинэ боломжуудыг нээн өгч шинэчлэлийг хөдөлгөгч хүч болж, компанийн нэр хүндийг өсгөж, үр ашгийг нэмэгдүүлдэг хэмээн бизнесийнхэн үздэг.







# КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД БАРИМТЛАХ ЗҮЙЛС

КНХ нь дараах 3  
асуудлын тэнцвэртэй  
байдлыг хангах ёстой.  
Үүнд:



Эдгээр үйл ажиллагаанууд нь хоорондоо харилцан уялдаа холбоотой бөгөөд КНХ-ыг хэрэгжүүлж, үр дүн гаргахад зайлшгүй чухал асуудлууд юм. Хариуцлагатай бизнес эрхлэхэд дараах асуудлын аль нэгийг нь орхигдуулахгүйгээр жигд авч явах шаардлагатай.





-Бизнесийн ёс зүйг  
эрхэмлэн дээдлэх

Нийтийн эрүүл мэнд,  
аюулгүй байдал

Байгаль орчинг  
хайрлан хамгаалах


Хүний эрхийг хүндэтгэн  
дээдлэх

Тогтвортой хөгжлийг  
хангахад хувь нэмрээ  
оруулах

Ажлын нөхцөл  
сайжруулах

Салбарын уялдаа холбоо,  
хамтын ажиллагаа  
сайжруулах





Нийгмийн үйл хэрэг, хөрөнгө  
оруулалт, хөгжил цэцэглэлтэд  
оролцох

Олон янзын соёл, хүмүүсийг  
хүндэтгэн үзэх

Ивээн тэтгэлэг, хандив  
туслалцаа үзүүлэх

Хэрэглэгчдийн сэтгэл ханамж,  
шударга өрсөлдөөний  
зарчмуудыг баримтлах

Авилгал, хээл хахуулиас  
ангид байх

Хариуцлага, ил тод байдал,  
гүйцэтгэлийн талаар  
тайлагнадаг байх

Гадаад дотоодын нийлүүлэгч,  
түншүүдтэй эрх тэгш харилцаа  
холбоо тогтоох

**“Компаниудын нэр хүнд бий болгоход  
20 жил шаардагдана. Харин алдахад 5 минут л  
хангалттай. Иймээс нийгмийн хариуцлагын талаар  
ямагт анхаарч байх хэрэгтэй”**

*УОРРЭН БАФФЕТ  
/Хөрөнгө оруулагч, дэлхийн хамгийн  
өглөгч бизнесмен/*



КОМПАНИЙН НИЙГМИЙН  
ХАРИУЦЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД  
ХАМТРАГЧДЫН ОРОЛЦОО,  
ХӨДӨЛГӨГЧ ГОЛ ХҮЧИН ЗҮЙЛС

4



## КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ХАМТРАГЧДЫН ОРОЛЦОО

**К**НХ-ыг хэрэгжүүлэхэд хэрэглэгч, ажиллагсад, бэлтгэн нийлүүлэгчид, хөрөнгө оруулагчид, нийгмийн байгууллагуудын олон талын харилцаа холбоо, оролцоо зайлшгүй хэрэгтэй. Эдгээр нь шүүд болон шүүд бусаар бизнесийн үйл ажиллагаанд оролцож, нөлөөлж байдаг ба бизнесийн үйл ажиллагаа, үр ашигт мөн л харилцан адилгүй ашиг сонирхлын үүднээс ханддаг.

### ТӨР ЗАСАГ

КНХ-ын хөгжилд чухал нөлөөтэй хүчин зүйл болох холбогдох талууд хоорондын сайн харилцаа, сайн засаглалыг бий болгох суурь орчныг бүрдүүлэхэд төр оролцоно. Төр оролцохдоо хуулийн заалтууд, үр нөлөөтэй шүүх систем, хараат бус хэвлэл мэдээллийн хэрэгсэл, компанийн сайн засаглал, хуулийн талаар тогтмол, нээлттэй зөвлөгөө, сайн туршлагуудыг түгээн дэлгэрүүлэх ажлыг идэвхжүүлж дэмжих, мөн татвар бүүруулах, урамшуулал олгох, КНХ-ын стандарт, зааварчилгаа зөвлөгөөгөөр хангах, санхүүжүүлэх дэмжлэг үзүүлэх, нийгэм, байгаль орчны асуудлыг шийдэхэд иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшлийнхэнтэй хамтран СТРАТЕГИЙН ТҮНШЛЭЛИЙГ бий болгож, КНХ-ын талаарх төрийн бодлогыг орон нутаг, улсын хэмжээнд хэрэгжүүлж оролцох зэргээр дэмжин хамтарч ажилладаг. Бизнесийн таатай орчинг бүрдүүлэх, хууль эрх зүйн орчинг хангах, журам дүрмийг хөнгөвчлөх гээд бодлогын шинжтэй арга хэмжээнүүдийг авч бизнесийнхэнд үйл ажиллагаагаа чөлөөтэй явуулах боломжийг Засгийн газар ханган өгөх ёстой.







### **ОРОН НУТГИЙН УДИРДЛАГА**

Тухайн бүс нутагтаа үйл ажиллагаа явуулахдаа Орон нутгийн засаг захиргааны байгууллагатай хамтран ажиллах чиглэлээ эхнээсээ нарийвчлан тохирч ажиллах нь зүйтэй. Орон нутгийн байгууллага, хүмүүстэй хамтарч ажиллах нь таны бизнест өргөн хүрээтэй үр ашиг авчирна. Орон нутагтай холбоотой ажиллах маш олон боломж бий болгодог. Зарим компаниуд тухайн бүс нутагтаа хүмүүнлэгийн болон ивээн тэтгэлэг үзүүлж хамтран ажиллаж байгаа нь үр дүнгээ өгч байна.

### **КОМПАНИ**

Нэгэнт бизнес нь нийгмийн ажил эрхлэлт, баялаг бүтээхэд гол үүрэг гүйцэтгэж байгаа тул КНХ нь аливаа компаний удирдлагын (менежментийн баг) гол асуудал болж байна. Эрсдэл, боломжуудыг зөв удирдан төлөвлөх, өөрийн хамтрагч түншүүдийг үйл ажиллагаандаа өргөнөөр татан оруулах, компанийхаа нэр хүндийг өсгөх зэрэг олон асуудал компаний удирдлагад оногддог. Энэ бүхнийг зөв хийх, амжилт олох үндэс нь КНХ байдаг.

### **ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ**

КНХ-ын чиглэлээр баримтлаж ажиллах чиглэл, төсөв санхүү, хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр нь тодорхой байснаар хөрөнгө оруулагчдын хувьд оны эхэнд төсөвт тодорхой тусгагдаж өгснөөр зориулалтын бус, цаг үеийн шаардлагаар дэмий хөрөнгө зарцуулах зэргээс сэргийлэх давуу талтай.









## **ХЭРЭГЛЭГЧ**

Хэрэглэгчтэй хариуцлагатай хамтран ажиллах нь бизнесийг тогтвортой үргэлжлэх нөхцлийг бий болгодог. Хэрэглэгчдийн итгэлийг хүлээх хамтын ажиллагаа бол бүтээгдэхүүн, үйлчилгээний өөрчлөлт тус бүр дээр хэрэглэгчээ сонсож чаддаг байх явдал юм. Мөн бүтээгдэхүүн үйлчилгээний танилцуулгаа тодорхой, давхар агуулгагүй, үнэн зөв бичсэн байх, халамж шаардлагатай ахмад настай болон хөгжлийн бэрхшээлтэй хэрэглэгч үйлчлүүлэх тав тухтай нөхцлийг хангах, алдаа гаргасан тохиолдолд нэн даруй хариу арга хэмжээ авдаг байх зэрэг нь хэрэглэгчийн итгэлийг төрүүлж, КНХ-аа ухамсарладаг хэмээн дүгнэх нөхцлийг бүрдүүлж өгдөг.

## **АЖИЛТАН, АЛБАН ХААГЧИД**

Хүний нөөцийн цалин хөлс, нийгмийн халамж, ёс зүй, нууцлалын бодлогыг ямар түвшинд барьж ажиллахаа тодорхой тохирсноор ажилтнуудын компанидаа итгэх итгэлийг нэмэгдүүлж, хүлээлт нь зохистой түвшинд байх боломж бий болно.

## **НИЙЛҮҮЛЭГЧ**

Татвараа төлдөггүй, хууль бус, хүний эрүүл мэндэд хортой бүтээгдэхүүн нийлүүлэгчтэй ажиллах нь таны бизнест ямар хор үршиг тарьж болохыг урьдчилан тооцоолох нь зүйтэй. Таны хувьд ч гэсэн бэлтгэн нийлүүлэгчдэдээ шударга хандаж, төлбөр тооцоогоо цаг тухай бүрт нь хийж, харилцан ашигтай шударга нөхцлөөр хамтран ажиллаж байгаа нь дахин нэг компанийг нийгэмдээ хүлээн зөвшөөрөгдсөн, улсдаа татвараа шударгаар төлж, ажлын байр шинээр бий болгох нөхцлийг бүрдүүлж өгч буй хэрэг юм. Нийлүүлэгчээ зөв сонгох бас нэг чухал үзүүлэлт бол орон нутгийн нийлүүлэгчтэй хамтран ажиллаж, зардлыг бууруулан тухайн бүс орон нутагтай ийм удирдлагатай сайн харилцааг бий болгох явдал юм.



**“Бизнест цорын ганц хариуцлага л байдаг.  
Өөрөөр хэлбэл, тоглоомын дүрмийн дагуу үйл  
ажиллагаа явуулан бизнесийн орлого,  
ашгаа өсгөхөд бүхий л нөөц боломжоо зүй зохистой  
ашиглах явдал юм”**

*МИЛТОН ФРИДМАН  
/Эдийн засагч/*



5

КОМПАНИЙН НИЙГМИЙН  
ХАРИУЦЛАГЫГ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ, ТАНИУЛАН  
СУРТАЛЧЛАХ НЬ



## КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ

**Х**эдийгээр ISO26000 буюу КНХ-ын Олон улсын стандарт гарсан ч компани, аж ахуйн нэгж түс бүрийн бизнес, үйл ажиллагааны онцлогоос шалтгаалан КНХ-ыг хэрэгжүүлэх тогтсон төлөвлөлт, арга механизм гэж байхгүй.

КНХ-ыг хэрэгжүүлэхдээ өөрийн байгууллагын эрхэм зорилго, алсын хараа, бизнесийн соёл, салбарын үйл ажиллагааны чиглэлээр барьж буй төр засгийн бодлого, зорилт, улс орны эдийн засаг, хууль эрхзүйн орчин, бизнесийн өсөлт, байгаль орчны нөлөөлөл, болзошгүй эрсдэл, үйл ажиллагааны ерөнхий төлөв зэрэг олон хүчин зүйлийг цогцоор нь харах шаардлага гарна. Ялангуяа хэрэглэгч, харилцагч, хөрөнгө оруулагч, ажиллагсад, нийгэм, олон нийтийн талаар баримтлах бодлого, чиглэл, үйл ажиллагаа нь КНХ-ыг хэрэгжүүлэх

эхлэл болох тул компанийн шийдвэр гаргалт, стратеги, менежментийн процесс, хөрөнгө оруулалт зэргийн уялдаа холбоо нягт төлөвлөх шаардлагатай.

КНХ-ыг амжилттай хэрэгжүүлэхийн үндэс нь бүх талын оролцогчдын эдийн засаг, нийгэм, байгаль орчны талаар гаргах шийдвэрийг нэгтгэн, уялдуулан зохицуулах явдал юм.

Тухайн компанийн шийдвэр гаргалт, стратеги, менежментийн процесс, үйл ажиллагаануудын уялдаа холбоо нь КНХ-ын хэрэгжилтийн цөм нь болдог.

КНХ-ыг амжилттай сайн хэрэгжүүлэх үндэс нь компаний дээд удирдлагаас эхлээд ажиллагсад, нийлүүлэгч, түншүүд гээд бүхий л оролцогчид эдийн засаг, нийгэм, байгаль орчны талаар гаргах шийдвэрээ нягт уялдуулан зохицуулах явдал юм.







## КОМПАНИЙ НИЙГМИЙН ХАРИУЦЛАГАА ТАНИУЛАН СУРТАЛЧЛАХ НЬ

**К**НХ-ын бодлого, олон нийттэй харилцах бодлого зэргээ гарган олон нийтэд нээлттэй танилцуулах нь зорилтот бус элдэв саналаас татгалзах эелдэг шалтгаан болдог. Мөн КНХ-ын чиглэлээр гүйцэтгэсэн ажлуудаа хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах нь хэрэглэгч, харилцагч, нийлүүлэгчид болон, улс орны хэмжээнд танигдах маш сайн гүүр болж, хэвлэл мэдээллийнхэн энэ чиглэлээр үнэ төлбөргүй сурталчилж өгдөг төдийгүй цахим ертөнц хөгжсөн өнөө үед олон нийтийн талархлыг хүлээх магадлал ихтэй. Энэ төрлийн мэдээлэл нь таны бизнесийн өрсөлдөгчөөс ялгарах давуу талыг бий болгох төдийгүй

нийгэмд эерэг хандлага сэтгэлгээг төлөвшүүлэхэд ч нөлөөлж чадах боломжтой.

Түүнчлэн КНХ нь нэг удаагийн шинжтэй үйл ажиллагаа биш учир урт хугацааны нэр хүнд, үр ашгийг бий болгох үргэлжилсэн процесс болж хэрэглэгчдийг татаж, бусад нийлүүлэгч хамтрагчдын хувьд тантай хамтран ажиллах хүсэл сонирхлыг төрүүлэх болно. Мэдээж тунг нь тааруулж тодорхой тактиктай ажиллах ёстой.

КНХ-ын идэвхтэй үйл ажиллагаагаар дамжуулан бизнесийн тогтвортой байдлаа хадгалахыг хүсч байгаа бол анхнаасаа зөв бодлого, нягт төлөвлөлт, чанартай гүйцэтгэлд анхаарах нь зүйтэй.







## КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ҮР АШГИЙГ ХЭМЖИХ НЬ

**А**ливаа бизнесийн үйл ажиллагааны зорилго нь хэмжигдэхүйц байх шаардлагатай. КНХ ч мөн адил хэмжигддэг.

КНХ-ын үр дүнтэй байдал нь ажилтны шилжилт хөдөлгөөн, хөрөнгө оруулалтын санал, бүтээгдэхүүн үйлчилгээний борлуулалт, хэрэглэгчдээс авах үнэ цэнийн судалгаа, зардал хэмнэлт, компаний нэр хүнд, сэтгэл ханамжийн эерэг үнэлэлт зэргээр илэрдэг. Зөвхөн санхүүгийн хэмжүүрээр хэмжих нь түүний бодит утга, өртгийг алдагдуулдаг. КНХ-ын бодлогыг тогтвортой, урт болон дунд хугацаанд хэрэгжүүлсний дараа үр ашгаа хэмжих боломжтой. Олон улсын түршлагаас харахад КНХ-ыг хэрэгжүүлснээр компаний нэр хүнд

хамгийн багадаа 30 хүртэл хувиар өсгөх боломжтой гэж үздэг.

Эсрэгээрээ КНХ-ыг хэрэгжүүлсэн дүр эсгэж, тогтвортой бус нэг удаагийн нэр хүнд олох гэсэн ажлууд хийж, хэвлэл мэдээллээр төлбөрт мэдээлэл цацсанаар сөрөг үр дагавар ч гарч байсан тохиолдлууд байдаг.

КНХ-ын үзүүлэлтээ тодорхойлоход дараах судалгааг хийх шаардлагатай.

### **Үүнд:**

-Ижил гарааны нөхцөлтэй бизнестэй харьцуулах

-Хэрэглэгчийн тоо, орлого ашгийн дүнг харьцуулах

-Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааг авах

-Ажилтнуудын сэтгэл ханамжийн судалгаа, ажилтнуудын шилжилт хөдөлгөөн гэх мэт.



**“Хэзээ ч алдахгүй хөрөнгө  
оруулалт бол сайн сайхан,  
нинжин сэтгэл юм”**

*ХЕНРИ ДЭВИД  
/Философч/*



КОМПАНИЙН НИЙГМИЙН  
ХАРИУЦЛАГА БИЗНЕСИЙН  
УДИРДЛАГЫН ШИНЭ ХАНДЛАГА  
БОЛОХ НЬ

6



## КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА БИЗНЕСИЙН УДИРДЛАГЫН ШИНЭ ХАНДЛАГА БОЛОХ НЬ

**Б**айгууллага, аж ахуйн нэгжүүдийн хувьд КНХ-ыг амжилттай хэрэгжүүлэх эхлэл нь дээд удирдлага юм. Байгууллагын дээд удирдлагын дэмжлэг туслалцаа, итгэл үнэмшил чухал ач холбогдолтой бөгөөд /TONE AT THE TOP/ түүнчлэн ажиллагсад, хамтрагчдын оролцоо, хүчин чармайлт ч тодорхой нөлөө үзүүлдэг. КНХ-ыг хэрэгжүүлэхдээ тухайн байгууллагын стратеги, менежмент, шийдвэр гаргах процесс, үйл ажиллагаа зэргийн үялдаа холбоо сайн анхаарах хэрэгтэй байдаг.

КНХ нь аливаа бизнесийг дэлхий ертөнц, байгаль орчин, тухайн нийгмийн нэг салшгүй хэсэг гэж үздэг бөгөөд бизнес дангаараа оршин тогтнох боломжгүй нь тодорхой. Өөрөөр хэлбэл хэрэглэгч, ажиллагсад, нийлүүлэгчид, хөрөнгө оруулагчид, нийгмийн байгууллагууд гээд хамтрагчид буюу оролцогчидтой олон талын харилцаа холбоо, оролцоо хэрэгтэй. Эдгээр нь шууд болон шууд бус арга замаар бизнесийн үйл ажиллагаанд оролцож, нөлөөлж байдаг ба бизнесийн үйл ажиллагаа, үр ашигт мөн л харилцан адилгүй ашиг сонирхлын үүднээс ханддаг.

КНХ-ыг хэрэгжүүлээгүй тохиолдолд юу болох, ямар асуудлууд урган гарч болохыг нарийвчлан тодорхойлоход хамтрагчдын оролцоо чухал ач холбогдолтой юм. Тухайлбал хэрэглэгчид өөрсдийн хэрэгцээ шаардлагад хариуцлагагүй хандаж байна хэмээн үзэх бол нийлүүлэгчдийн зүгээс тухайн компанид итгэх итгэл буурах бол орон нутгийн байгууллагуудын хамтын ажиллагаа багасч хөрөнгө оруулагчдын бухимдал нэмэгдэнэ. Хамтрагчдыг бизнес, компанийн үйл ажиллагаанд оролцуулахын гол шалтгаан нь нийгмийн капиталыг бий болгох, эрсдэлийг багасгах, шинэчлэл өөрчлөлтийг эрчимжүүлэх, эдгээр асуудлуудыг компанийн стратегитай уялдуулах явдал юм.



## **НИЙГМИЙН КАПИТАЛЫГ БИЙ БОЛГОХ**

Компаниудад хэд хэдэн төрлийн капитал байдаг. Эдийн засгийн капиталыг банк, хөрөнгө оруулагчдаас авч болдог. Байгалийн капиталыг/түүхий эд гэх мэт/ зах зээлээс худалдан авч болно. Харин нийгмийн капиталыг хаанаас, яаж бий болгох вэ? Нийгмийн капиталыг тухайн компаний зүгээс нийгэмтэй тогтоосон харилцаа холбоо хэмээн ойлгож болох юм. Эдийн засаг, бизнесийн өнөөгийн орчин нөхцөлд тухайн компаний нэр хүнд гол асуудал болж байгаа нь нийгмийн капитал нь бусад капиталыг татах үндэс болох талтай. Нийгмийн капитал нь тухайн компаний “үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл” бөгөөд ажилчдын хувьд компанийхаа үйл ажиллагааны төлөө бүхий л чадал боломжоо өгөх үндэс, компанийн брэндийн өртөг, нэр хүндийг өсгөх эх үүсвэр болдог. Нийгмийн капитал нь хүчтэй, харилцан итгэлцсэн харилцаа юм. Нийгмийн капиталыг бий болгосноор мэдээлэл олж авах боломжийг нэмэгдүүлж, компанийн нэр нөлөөг дээшлүүлж, олон нийтийн итгэлийг өсгөдөг.

## **ЭРСДЭЛИЙГ БАГАСГАХ**

Хамтрагчдын оролцоо нь хэрэглэгчдэд чиглэсэн бараа бүтээгдэхүүнийг бий болгох, аюулгүй бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хүний эрхийг хангах, байгаль орчны болон хувьцаа эзэмшигчдийн асуудал зэрэгт анхаарлаа хандуулах боломжийг олгодог. Энэ утгаараа хамтрагчдын оролцоо нь эртнээс анхааруулах дохио болж өгдөг.

## **ШИНЭЧЛЭЛИЙН ЭХ СУРВАЛЖ**

Хамтрагчдын оролцоо нь мэдээллийн урсгалыг нэмэгдүүлж, бизнесийн боломжийг тодорхойлж өгдөг. Зарим компани хамтрагчдын оролцоог шинэ бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх, зах зээлд гаргах санаа, зөвлөмж ч гэж үздэг. Оролцогч, хамтрагчдадаа нээлттэй ил тод байх нь мэдлэгт тулгуурласан дэлхий ертөнцөд байр сууриа өсгөх үндэс болно хэмээн судлаачид үздэг. Түүнчлэн КНХ-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “төлөвлө, хий, хяна, сайжруул” гэсэн чиг хандлагын хэрэгжилтэд хэрэглэгчид, хувьцаа эзэмшигчид, ажиллагсад, нийлүүлэгчид, байгууллагуудын үүрэг хариуцлага ямар байгааг гаргах, хянах боломжийг бүрдүүлдэг.





**“Хүчирхэг бизнес бий болгох,  
сайн сайхан дэлхий ертөнцийг  
бий болгох хоёр нь харш зүйлс биш  
бөгөөд харин ч урт хугацааны  
ололт амжилтын үндэс болдог”**

*БИЛЛ ФОРД  
/Бизнесмен/*



НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН  
ОЛОН УЛСЫН ISO-26000 СТАНДАРТ

7





## ISO 26000 СТАНДАРТ ГЭЖ ЮУ ВЭ?

Олон улсын ISO 26000 стандартыг боловсруулахад олон орны мэргэжилтэн, экспертүүдээс бүрдсэн баг 2005 оноос эхлэн ажиллаж 2010 онд эцсийн хувилбарыг боловсруулан гаргасан.

Тухайн ондоо энэхүү стандартыг албан ёсоор Олон улсын стандартын байгууллага (International Standard Organization)-аас “Нийгмийн хариуцлагын удирдамж” ISO 26000 нэртэйгээр гаргасан бөгөөд Монгол улсад 2012 оноос албан ёсоор стандарт болгон батлан гаргаж байгууллагуудыг сайн дурын үндсэн дээр үйл ажиллагаандаа нэвтрүүлэн дагаж мөрдөхийг зөвлөж байгаа юм.

Стандартын гол зорилго нь аливаа байгууллагын тогтвортой хөгжилд оруулах хувь нэмрийг хөхүүлэн дэмжих, нийгмийн хариуцлагатай хамааралтай нийтлэг ойлголтыг зөв үхуулан таниулах, сурталчлах, санал санаачлагуудыг урамшуулах, сайжруулах үйл явцыг нийгмийн амьдралын хүрээний бүх шат, байгууллагын түвшинд сайн дурын үндсэн дээр бий болгох юм.

ISO 26000 стандартыг аливаа байгууллага сайн дурын үндсэн дээр хэрэгжүүлснээр нийгэм, хүний болон хөдөлмөрлөх эрх, байгаль орчин, хууль зүй, шударга ёс, улс төр, цаашлаад үндэсний болоод олон улсын хэмжээнд мөрдөж буй хэм хэмжээг сахин биелүүлэх, эдийн засгийн өсөлтийг хангах, тогтвортой байдлыг бий болгох боломжтой болох юм.







## ISO 26000 СТАНДАРТ ЯАГААД ЧУХАЛ ВЭ?

Байгууллагын урт удаан тогтвортой хөгжил гэдэг нь зөвхөн хэрэглэгчийг сэтгэл ханамжтай бүтээгдэхүүн, үйлчилгээгээр хангаад зогсохгүй байгаль орчинг бохирдуулахгүй, нийгэмд хариуцлагатай байх явдал юм. Иймээс төрийн байгууллагууд, хэрэглэгч, үйлчлүүлэгчид, олон нийтийн зүгээс нийгмийн хариуцлагатай байхыг тухайн байгууллагаас шаарддаг.

Алсын хараатай удирдагч нар удаан хугацаанд орших амжилт бол бизнесийн ёс зүйтэй, зүй бус үйлдэл гаргахгүй, хууран мэхлэх, хууль бус үйл ажиллагаанаас ангид байх явдал гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Тиймээс байгууллагын үнэт зүйлд заавал нийгмийн хариуцлагыг оруулж өгдөг байна.

Нийгмийн хариуцлагын талаар маш олон ойлголт, тодорхойлолтууд, гэрээ, зарчмууд, тунхаглалуудыг ОУ-ын байгууллагууд, компаниуд, судлаач эрдэмтэд гаргасан байдаг бөгөөд эдгээрийг дэлхийн хэмжээнд нэгтгэж нэг ойлголт болгон түгээхэд энэхүү ISO 26000 стандарт чухал үүрэгтэй юм.



## ISO 26000 СТАНДАРТ

Нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэхээр шийдвэрлэнэ гэдэг нь байгууллагын тогтвортой урт хугацааны хөгжилд хувь нэмэр оруулахаар шийдсэн гэсэн үг билээ. Гэвч нийгмийн хариуцлагыг ингэж хэрэгжүүлнэ гэсэн тогтсон загвар байхгүй учир ISO 26000 стандартад зааж өгсөн 7 зарчмыг өөрийн байгууллагын онцлогт тохируулан мөрдөж хэрэгжүүлж ажилласан нөхцөлд нийгмийн хариуцлагыг олон улсын жишигт нийцүүлэн амжилттай хэрэгжүүлж тавьсан зорилгодоо хүрч чадах юм.

### **Зарчим 1. ТАЙЛАГНАХ**

Нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэгч байгууллага өөрийн үйл ажиллагааныхаа нийгэм, эдийн засаг, хүрээлэн буй орчинд ямар нэг нөлөөлөл үзүүлснээ сайн дурын үндсэн дээр ил тайлагнах (ISO 26000 стандарт, Зүйл 4.2)

Нийгмийн хариуцлагын тайланг ихэвчлэн жилд нэг удаа хэвлэн гаргадаг бөгөөд байгууллагын тухайн жилд гаргасан шийдвэр, явуулсан үйл ажиллагаа нийгэм, эдийн засаг, байгаль орчинд хор хөнөөл учруулаагүй гэдгийг харуулж байдаг. Ингэж тайлан гаргах нь байгууллага, нийгэм хоёрт хоёуланд нь сайн нөлөө үзүүлдэг. Байнга тайлагнаж байх нь нийгмийн уур амьсгалыг зөв бий болгоход чухал үүрэг гүйцэтгэдэг.

### **Зарчим 2. ИЛ ТОД БАЙДАЛ**

Тухайн байгууллагын нийгэм, эдийн засаг, хүрээлэн буй орчинд нөлөөлөх чиглэлээр гаргаж байгаа шийдвэр, явуулж буй үйл ажиллагаа ил тод байх (ISO 26000 стандарт, Зүйл 4.3)

Өөрсдийн явуулж буй үйл ажиллагааны талаар нийгэм, олон нийтэд зөв, бодит мэдээллийг ил тод хүргэж байх нь тухайн байгууллагын үйл ажиллагаанд шууд болон шууд бусаар эерэг нөлөөг авчирч байдаг. Энд мэдээж байгууллагын нууцад хамаарах мэдээллүүд хамаарахгүй.

### **Зарчим 3. ШУДАРГА ЁС**

Аливаа байгууллага нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэхдээ шударга ёс зүйтэй байх (ISO 26000 стандарт, Зүйл 4.4)



Шудрага, ёс зүйтэй байх, түүний үнэ цэнэ хүн, амьтан, байгаль, ажиллагсад, сонирхогчид, оролцогчдын ашиг сонирхолын тэгш шудрага байдлыг хамгаалдаг.

#### **Зарчим 4. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН СОНИРХОЛЫГ ХҮНДЭТГЭХ**

Нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэхэд оролцогч талуудын эрх, ашиг сонирхолыг хүндэтгэх, харгалзан үзэх(ISO 26000 стандарт, Зүйл 4.5) Эзэд, үйлчлүүлэгч, худалдан авагчид бусад хувь хүн, оролцогч талуудын зөрчлөөс шалтгаалан бэрхшээл үүсч болох боловч анхнаас нь оролцогч талуудын эрх ашиг сонирхлыг хүндэтгэн үзэх зарчмыг мөрдөж чадсан бол том зөрчил маргаанаас зайлсхийх боломжтой байдаг.

#### **Зарчим 5. ХУУЛЬ ДҮРМИЙГ САХИХ**

Аливаа байгууллага нь үйл ажиллагаандаа хууль дүрмийг заавал сахин биелүүлэх үүргийг хүлээн зөвшөөрөх (ISO 26000 стандарт, Зүйл 4.6) Мэдээж үйл ажиллагаа явуулж буй улс, орон нутгийнхаа хууль дүрмийг сахин биелүүлэх нь хамгийн наад захын хариуцлагын асуудал бөгөөд энэ нь тухайн орон нутагт амжилттай бизнесээ явуулах нөхцөл боломжийг бий болгож байдаг.

#### **Зарчим 6. ОЛОН УЛСЫН НОРМ, ХЭМ ХЭМЖЭЭГ МӨРДӨХ**

Байгууллага нь өөрийн үйл ажиллагаатай холбоотой олон улсын норм, хэм хэмжээг хүндэтгэн дээдэлж, тухайн орны хууль дүрмийн адил сахин биелүүлэх (ISO 26000 стандарт, Зүйл 4.7)

Олон улсын норм, хэм хэмжээг сахин биелүүлдэггүй байгууллагатай хамтран ажиллахгүй байхыг мөн анхаарах хэрэгтэй.

#### **Зарчим 7. ХҮНИЙ ЭРХИЙГ ХҮНДЭТГЭХ**

Аливаа байгууллага нь хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэж, үүний ач холбогдол, нэгдмэл шинжийг мэдэж ханган биелүүлдэг байх (ISO 26000 стандарт, Зүйл 4.8)

*Дээрх 7 энгийн зарчмыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж чадсанаар нийгмийн хариуцлагатай байгууллага гэж нүүр бардам хэлж болно.*





## ISO 26000 СТАНДАРТЫГ ХЭРЭГЖҮҮЛСЭНЭЭР ЯМАР ДАВУУ ТАЛТАЙ ВЭ?

Нийгмийн хариуцлагын үндсэн хэсгүүд нь эдийн засаг, эрүүл мэнд, аюулгүй байдал, борлуулалт, нийлүүлэлт, үйлчилгээний гинжин хэлхээтэй салшгүй холбогддог. Жишээлбэл, танай байгууллага хогны асуудлаа шийдэж чадсан бол байгаль орчинд ээлтэй байна гэж үзэж болно. Ажилчдаа ажиллуулахдаа хөдөлмөрийн хууль зөрчдөггүй, илүү цагаар ажиллуулсан бол түүнийх нь хөлсийг өгдөг бол хөдөлмөрлөх эрхийг дээдэлдэг гэж үзнэ.

Нийгмийн хариуцлагатай байснаар танай байгууллагад дараах давуу талууд бий болдог. Үүнд:

*Нийгмийн хариуцлагатай байна гэдэг нь завсгал хандив тусламж өгч, мөнгө их зарцуулж, буяны үйл хийснээр илэрхийлэгдэхгүй танай байгууллага өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрхэн хариуцлагатай хандаж байгаагаар илэрхийлэгдэнэ.*



# ISO 26000 СТАНДАРТЫГ ХЭРХЭН ХЭРЭГЖҮҮЛЭХ ВЭ?

Нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэхээр шийдсэн байгууллага шийдвэр гаргах болон зохион байгуулах үйл ажиллагааны хүрээнд дараах үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдийг анхааралтай судлан, дагаж мөрдөн хэрэгжүүлэх хэрэгтэй. Үүнд:

## *КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН 7 ХҮРЭЭ*



**“Бизнес бол мөнгөний тухай асуудал биш. Энэ бол хариуцлагын тухай асуудал юм. Өөрөөр хэлбэл энэ нь хувийн ашиг, сонирхол биш, нийгмийн сайн сайхны тухай асуудал юм”**

*АНИТА РОДДИК  
/Бизнес эмэгтэй/*



КОМПАНИЙН НИЙГМИЙН  
ХАРИУЦЛАГЫГ  
ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙСАН  
ТУРШЛАГА

8



## МОНГОЛЫН КОМПАНИУДЫН ХЭРЭГЖҮҮЛСЭН САЙН ТУРШЛАГУУД

**К**НХ-ыг Монгол улсад амжилттай хэрэгжүүлж байгаа жишээ олон бий. Гэхдээ доорх жишээнүүд нь тус бүртээ өөр өөрийн онцлогтой бөгөөд цаашдаа Монгол улсад үр дүнгээ өгөх, олон талт хамтын ажиллагаа, оролцоонд түшиглэж үр дүнтэй хэрэгжсэн, тогтвортой хэрэгжүүлж байгаа төслийн талаар танилцуулъя.

### МОБИКОМ КОРПОРАЦИ ХХК-МОБИ ТЭМҮҮЛЭЛ ТӨСӨЛ

“Монголын ирээдүй хүүхэд залуусаа зорилго тэмүүлэлдээ хүрэхэд нь бид хамтдаа хэрхэн хөтлөх вэ?” хэлэлцүүлгийг өрнүүлснээр эхэлсэн. “Мобиком Корпораци аль чиглэлд нийгмийн хариуцлагын үйл ажиллагааг чиглүүлэх ёстой вэ?” гэсэн асуултад хэрэглэгчид санал нэгтгэйгээр “Монгол улсыг хөгжүүлэх үндсэн салбарт түлхүү анхаарах ёстой” гэж хариулсан бол, “Хөгжлийг авчрах үндсэн салбар нь аль салбар вэ?” гэсэн асуултад хэрэглэгчдийн 94% нь “Боловсролын салбар”, “Хөгжлийг хэн авчрах вэ?” гэсэн асуултанд “Ирээдүй үе-хүүхэд залуучууд” гэж хариулж байв. Эхний шатны санал асуулгад орон даяар яваад зогсохгүй дэлхийн өнцөг булан бүрт суугаа Монголчууд маш идэвхтэй оролцож нийт 79'357 санал Моби Тэмүүлэл төсөлд ирүүлсэн. Төслийн хоёрдугаар шатны бүх нийтийн санал асуулгын үр дүнд 206,885 санал ирж “Багшийн үнэлэмжийг нэмэгдүүлэх хөтөлбөр”- хамгийн их саналыг авсан байв. Иймд Мобиком корпораци энэхүү төслийг дангаараа хэрэгжүүлэхгүй тул боловсролын салбарт ямар бодит дэмжлэг хэрэгтэй байгаа талаар тус салбарын 160 гаруй багш, сурган хүмүүжүүлэгч, эрдэмтэн мэргэд, оюутан сурагчид, мэргэжилтнүүд, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөгчдийг урьж оролцуулан, нээлттэй хэлэлцүүлгийг дахин зохион байгуулан, хамтран төслөө боловсруулсан юм. Ийнхүү Ерөнхий боловсролын сургууль, багш нарт чиглэсэн боловсролын салбарын хөгжилд хүчтэй дэмжлэг үзүүлэхүйц





тус төслийн нээлт 2010-2011 оны хичээлийн жилээс эхэлсэн бөгөөд нийслэлийн Баянзүрх дүүргийн 19 сургууль, Говь-Алтай, Дорноговь аймгийн тус бүр 5 сургууль, мөн Өмнөговь аймгийн Цогтцэций сумын сургуулиудад хэрэгжин, үр дүнг нь хамтдаа гаргасан юм. Энэхүү төсөлд ерөнхий боловсролын сургуулийн 2500 багш, 19000 сурагч хамрагдсан байсан бөгөөд, төслийн хэрэгжилтэд 650 сая төгрөг зарцуулагджээ. Мобиком Корпорацийн хэрэгжүүлсэн “Цахим сургалт” төслийн хүрээнд дээрх сургуулиудад өндөр хурдны интернет холбож, цахим удирдлага хяналт, сургалтын програм нэвтрүүлж, портал цахим хуудастай болгож, сүүлийн үеийн өндөр үзүүлэлттэй ширээний болон зөөврийн компьютер, дижитал проектороор тоноглогдсон иж бүрэн танхимыг байгуулан өгсөн юм. Төсөл хэрэгжсэнээр сурагчдын дүн, ирцийн мэдээллийг электрон хэлбэрт шилжүүлэн, багш, сурагч сургалтын нэгдсэн мэдээллийн сантай болох, сургууль сургалттай холбоотой аливаа судалгааг онлайнаар авах, ил тод шударга үнэлэх, сурагчдын сурлагын амжилттай нь холбон судалгаа хийх, цахим хичээл, цахим шалгалтын сан, номын сан байгуулан цаасгүй технологи ашиглан зардал мөнгө хэмнэх, өдөр тутмын үйл





ажиллагааг хялбаршуулах, сургуулийн ажиллагаанд иргэд, эцэг эхийн бүтээлч оролцоог нэмэгдүүлэх зэрэг өргөн боломж нээгдсэн.

### **ХААН БАНК САН - “ӨРХ ГЭР – НОГОО” ТӨСӨЛ**

Улаанбаатар хотын Эмэгтэйчүүдийн зөвлөл, “Эх үрс – Энэрэл” хөдөлгөөний хэрэгжүүлдэг “Өрх гэр- ногоо” төслийг санхүүжүүлжээ. “Өрх гэр–Ногоо” төсөл анх 2002 онд Улаанбаатар хотын 10 өрхөд ногоо тарьж, амьдралын чанараа сайжруулах арга барилд сурган эхэлж байсан үеэс хотын олон дүүргийн 520 гаруй өрхийг хамарсан өргөн хүрээтэй, үр өгөөжтэй төсөл болон хэрэгжиж байна. “Өрх гэр -Ногоо” төсөлд хүнсний ногоо тарих сонирхолтой ч энэ талын мэдлэг, туршлагагүй өрх толгойлсон эмэгтэйчүүд, орлого багатай өрх болоод ажилгүй эмэгтэйчүүдийг хамруулдаг. ХААН Банк Сан нь 2009 оноос эхлэн уг төслийг санхүүжүүлж эхэлсэн бөгөөд 2011 он хүртэлх 3 жилийн хугацаанд нийт 20 гаруй сая төгрөгийн санхүүжилтийг зарцуулсан байна.

ХААН Банк Сангийн 2011 оны санхүүжилтийн үр дүнд Сонгинохайрхан, Сүхбаатар, Баянзүрх болон холын 2 дүүрэг болох Налайх, Багахангай зэрэг 5 дүүргийн нийт 80 өрхийг хороодоор нь сонгон авч, хүнсний ногоо, жимсний модны үр үрсэлгээ, бордоо болон хүлэмжийн материал зэргийг үнэ төлбөргүй олгон төсөлд хамруулсан байна. Энэхүү төслийг хэрэгжүүлснээр хангамж, хүнсний аюулгүй байдлыг сайжруулах, өөрийн гараар арчилж ургуулсан “Эрүүл хүнс”-ийг хүнсэндээ хэрэглэх дадал хэвшлийг бий болгох замаар тэдний амьдралын хэв маягийг өөрчилж өгснөөр төслийн гол үр дүн оршиж байна.

### **ХААН БАНК САН - “ХАВДРЫН ЭСРЭГ ҮНДЭСНИЙ АЯН”**

ХААН Банкны эрхэм зорилгод тусгасан “Хүмүүсийн амьдралыг бодитой өөрчилж, нийгмийн сайн сайханд хувь нэмэр оруулах” хэмээх хэсгийг ХААН Банк Сан эрхэм зорилгоо болгон хэрэгжүүлдэг. Тус сангийн тогтвортой хэрэгжүүлж ирсэн “Хавдрын эсрэг үндэсний аян”-ны үзлэг оношилгоо төслийг танилцуулж байна.



Ард иргэдийн эрүүл амьдралын төлөө ХААН Банк, Хавдар Судлалын Үндэсний Төв /ХСҮТ/, Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевиз /МҮОНРТ/ хамтран 7 дахь жилдээ “Хавдрын эсрэг үндэсний аян”-ыг хэрэгжүүлж байна. 2017 онд “Хавдрын эсрэг үндэсний аян”-ны үзлэг оношилгооны хүрээнд орон нутгийн ард иргэдийг 6 төрлийн хавдар өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд хамруулах, орон нутгийн эмч мэргэжилтнүүдийг нарийн мэргэжлийн сургалт, сайн дурын ажилтнуудыг сургалтад хамруулах, ард иргэдэд хорт хавдраас урьдчилан сэргийлэх мэдлэг мэдээллийг түгээх, эрт илрүүлгийн ач холбогдлыг таниулах ажилд онцгойлон анхаарчээ. Хорт хавдраас урьдчилан сэргийлэх, эрсдэлт бүлгийг үзлэгт хамруулах, эрт илрүүлэх, хорт хавдар үүсгэгч халдвараас сэргийлэх мэдлэгийг дээшлүүлэх ач холбогдолтой үндэсний хэмжээний “Хавдрын эсрэг үндэсний аян” өнгөрсөн 2010-2016 оны хугацаанд 100,000 гаруй иргэнийг хавдрын цогц үзлэг оношилгоонд хамруулжээ. ХААН Банкны хувьд 2017 оныг оролцуулан 7 жилийн хугацаанд тус аяныг хэрэгжүүлэхэд 1 тэрбум төгрөгийн санхүүжилт үзүүлж, орон нутгийн 2700 орчим ажилтнаа эрүүл мэндийн сайн дурын идэвхтэнээр бэлтгэж хавдар өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдээллийг олон нийтэд түгээгээд байна.

## **ДОРНОД АЙМАГ-ДЭЛГЭРЭХ ЭХ ХХК**

Заавал их хэмжээний хөрөнгө оруулалт нийгэмд үзүүлэхээс илүүтэйгээр үйл ажиллагаагаа хуулийн хүрээнд явуулж байгаа, аймаг сумтайгаа хамтран нийгэмдээ сайн жишээ болж яваа орон нутгийн бахархал болсон компаний жишээг танилцуулж байна.

Тус компаний хувьд одоогоор 36 хүнийг ажлын байраар хангаж байгаа бөгөөд үйл ажиллагаагаа тогтвортой явуулж, өөрсдийн тариалсан хүнс ногоогоороо сум, аймгийн иргэдээ ханган, үйл ажиллагаагаа өргөтгөн ажиллаж байна. Тус компаний хувьд татвараа цаг хугацаанд нь тушааж, ажилтнуудынхаа нийгмийн халамжийг сайжруулах зорилгоор жил бүр тодорхой тооны ажилтнуудаа байрны урьдчилгаа олгож байна. Мөн



жил бүр аймаг сумын иргэдээсээ нэн ядуу иргэдийг судалгаанд үндэслэн тодруулж, тогтмол туслаж дэмжин ажиллаж, жил бүр сум аймгийн шилдэг 5 оюутны сургалтын төлбөрийг төлдөг байна. КНХ-ын бас нэг гол үзүүлэлт болох байгаль орчиндоо ээлтэй үйл ажиллагаа явуулж, аймаг сумынхаа гудамжийг цэцэрлэгжүүлэх, хог хаягдлыг ангилан ялгаж хаях чиглэлээр шинэ технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлжээ.

### **М-СИ-ЭС ПРОПЕРТИ ХХК-ШИНЭ ГЭР ТӨСӨЛ**

2011 оноос “Шинэ гэр” төслийг эхлүүлсэн. Нийгмийн тэр дундаа залууст тулгамдаж буй бэрхшээлтэй асуудлууд болоод байгаа орон сууц, утаа, замын түгжрэл зэргийг шийдвэрлэхэд хувь нэмэр оруулахад тус төслийн зорилго оршино. Хан-Уул дүүрэгт, Яармагийн гүүрний баруун талд байрлах “Шинэ гэр” хороолол нь залуу гэр бүлийг бага талбайтай, боломжийн үнэтэй орон сууцаар хангах, амьдралын шинэ хэв маягийг бий болгох зорилготой. Монгол Улсын Засгийн Газраас хэрэгжүүлж буй 100 мянган айлын орон сууц хөтөлбөрт “Шинэ гэр” залуусын хороолол багтсан бөгөөд нэг жилийн хугацаанд 1624 айлын орон сууц барьж, ашиглалтанд оруулахаар ажиллаж байна. “Шинэ гэр” төсөл хэрэгжсэнээр орон сууцжуулах замаар агаарын бохирдолыг бууруулах, замын түгжрэлийг сааруулахад бодитой хувь нэмэр оруулах юм.

### **ГОВЬ КОМПАНИ-ХОГ ХАЯГДЛЫГ БУУРУУЛАХ ТӨСӨЛ**

Байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулах зорилгоор үйлдвэрлэлд ашиглагдах химийн бодисыг сонгохдоо био задрал сайтай, хүнд металийн хольцгүй, амьтны гаралтай, байгаль орчин, хүний эрүүл мэндэд хор хөнөөлгүй, бодисыг сонгож, захиалах, хадгалах, хэрэглэх, хаяхдаа /ГЖ 11:05/ “Будаг, химийн бодис захиалах, хүлээн авах, хадгалах журам” болон тухайн бодисын хэрэглээний стандарт болон аюулгүй ажиллагааны зааварчилгааг чанд мөрдөж ажилладаг. Үйлдвэрлэлээс гарсан технологийн болон ахуйн хог хаягдлыг ангилж ялган, дахин боловсруулалт хийх, гадагш зарж борлуулах,







байгаль орчинд хор нөлөө учруулахгүй хэмжээнд цэвэршүүлж хаях арга хэмжээг авч, зохих журмуудыг боловсруулан мөрдөж ажилладаг.

Технологийн хаягдал - Утасны үзүүр, өөдөс деталь зэргээр дахин боловсруулалт хийж дээдлэн ажиллах, хямд өртөгтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэх өө сэв, хялгасыг гадагш борлуулах, үйлдвэрээс гарч байгаа бохир усыг төвлөрсөн сүлжээнд нийлүүлэхийн өмнө цэвэршүүлэх байгууламжаар 2 үе шатаар шүүж, цэвэршүүлсэн усан дахь умбуур бодис, аммоний хэмжээг зөвшөөрөгдөх нормд хүргэж нийлүүлдэг ба сар болгон сорьц авч УСУГ-н лабораторид шинжлүүлж байна.

Ахуйн хог хаягдал - ХУД-ийн Хот тохижуулах үйлчилгээний компанитай жилээр гэрээ хийж 7 хоногт 2 удаа ирж “Говь” ХК-ний түр хадгадах цэгээс сард 24 тн хог, жилд 288 тн хог хаягдлыг ачиж тусгай хогийн цэгт хаядаг. Цаасыг тусад нь ангилж, дахин боловсруулах үйлдвэрүүдэд тушаадаг.



## ГАДААДЫН КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛСЭН САЙН ТУРШЛАГУУД

**“Лафор” ХХК-** Ажилчдынхаа хүүхдүүдийг тэтгэлэгт хөтөлбөрт хамруулан үйл ажиллагаа явуулдаг тосгоныхоо боловсролыг дэмжин бага сургуулийн тэргүүн байранд хандивыг тогтмол өгч иржээ. Мөн тэд хүүхдүүдтэйгээ явган аялал хийхэд нь орон нутгийн багш нарт санхүүгийн дэмжлэг үзүүлж байна. Түүнчлэн нийгмийн хариуцлагаа ухамсарласны өөр нэг шинж тэмдэг нь компанийхаа оффисийг Пиатра Неамт-с Разбоени руу нүүлгэснээр үйл ажиллагаагаа явуулж буй нийгэмдээ татвар төлж байгаагаар илэрч байна.

**“Ракордекс” ХХК-ын** жишээнд нийгмээ сайжруулахын тулд үйлдвэрээ урьдаас төлөвлөсөн газар байгуулсан. Уг талбай нь анх Варатекийн түүхэн сүм хийд бүхий намган дээр байрласан жуулчдын идэвхигүй бүс байсан бол өөрчлөгдөн, барилга байгууламж

баригдсан, өвс ногоо тариалсан, тус газар нутгийн байдал дээр цэцэрлэгт хүрээлэнтэй олон нийтийн бүс бий болсон.

Эмэгтэйчүүдийн ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх (эмэгтэйчүүдийг мэргэжлийн сургалтанд хамруулан) зорилготой Европын төсөлд (Минерва- тэгш эрхийн төлөөх эмэгтэйчүүдийн эрх чөлөө 2010-2013) оролцсоноор тус нийгмийн оролцоог хийсэн.

Ракордекс нийгмээ хөгжүүлэхээс гадна санхүүгийн ашиг авчирсан уг төслийг зүүн хойд Румын улсад хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн. Байгуулагдсанаасаа хойш Point Max Solutions эмзэг бүлгийхэн тэр дундаа хүүхдүүдэд чиглэсэн олон янзын нийгмийн үйл ажиллагаанд оролцсоор ирсэн.

Өнгөрөн 4 жилд уг пүүс Casa Sperantei Hospice ТББ-т арга хэмжээ зохион байгуулах,





хэрэгжүүлэх мөн санхүүжилт авахад нь дэмжлэг үзүүлсэн. Уг ТББ нь өвчин намдаах эм хэрэглэдэг хүнд өвчтэй хүүхдүүдэд анхаарал халамж тавьдаг. 2010 онд уг пүүс Principesa Margareta Сангийн үйл ажиллагааг дэмжин цалингүй ажилласан бөгөөд хүүхдүүдэд зориулан үлгэр ярьдаг оройг зохион байгуулсан. Тэд бизнесийн

түншүүдээсээ хүүхдүүдэд зориулсан бодит хандивт (чихэр, тоглоом) оролцохыг хүссэн, жүжигчид, телевизийн хөтлөгч зэрэг танилын сүлжээнд багтсан алдартнуудаасаа үлгэр уншиж өгөх, гарын үсэг зурах урилга явуулсан. Телевиз сонин хэвлэлийн тусламжтайгаар уг арга хэмжээнд 200 гаруй хүүхдүүд эцэг эхтэйгээ оролцжээ.







## ҮНДЭСТЭН ДАМНАСАН ТОМООХОН КОМПАНИУДЫН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

**Vodafone** эмзэг бүлгийнхэнд зориулсан тогтвортой бүтээгдэхүүн, үйлчилгээний хөгжилд хөрөнгө оруулдаг-сонголын бэрхшээлтэй хүмүүст зориулсан SMS үйлчилгээ, ахмадад зориулсан тусгай төлөвлөгөө гэх мэт. Үүний зорилго нь бизнесээ тогтвортой хөгжүүлэхийн зэрэгцээ бүх сонирхлын бүлгүүдийн бодит хэрэгцээнд анхаарал хандуулах явдал юм.

**Coca Cola-ийн** нийгэмдээ бий болгосон санаачлагууд ихэвчлэн нийгмийн бүлэг бүрийн тодорхой хэрэгцээг хангахын зэрэгцээ усны нөөцийг хамгаалахад чиглэдэг. Тус компаний арга зам нь ТББ-ууд, орон нутгийн сайн дурын хөтөлбөрүүд, нийгмийн хөрөнгө оруулалтын газруудтай түншлэлийн хүрээнд хамтран ажилладаг. Coca-Cola Hellenic Tasuleasa Social-тай сүүлийн 3 жил Green 003 төсөл дээр хамтран ажиллаж байгаа ба уг төслөөр Dorna хөндийг цэвэрлэж, мод тарьж

иргэний нийгмийн цөмүүд бий болсон. Илүү тодорхой хэлбэл эдгээр нийгэмлэгийн хүүхдүүд ТББ, төслийн удирдлага, харилцаа холбоо, хөгжилд үзүүлэх удирдлагуудын үүрэг, анхны тусламжийн талаар хичээл заалгасан. Уг оролцсон хүүхдүүд бусад сургууль, ахлах сургуулиудаас хүүхдүүд шинээр элсүүлж тус компанитай хамтран төслөө өөрсдөө хөгжүүлж эхэлдэг (компаниас тэднийг бага хэмжээний мөнгөөр дэмждэг). Үүний нэг жишээ нь тус нийгэмлэгүүдийн хэрэгжүүлсэн ангилсан түүхий эдээр илүүдэл зардал цуглуулах хөтөлбөр юм. Эдгээр бүх төслүүдэд Coca-Cola Hellenic-ийн ажилчид хүүхдүүдтэй сайн дураараа хамтран ажилладаг. Уг төсөл нь хүний нөөцөө дайчлахад санхүүгийн нөөцөд бага төвлөрдөг. Экологийн боловсролыг дэмжихийн тулд Dorna Candreni-д нөөцийн төв болон сургалтын ой бий болсон. Мөн бүс нутагт ус шүүх систем хэрэгжсэн ба ингэснээр байгалийн



шүүлтүүрээс (шаварлаг хөрс,зэгс гэх мэт) гоожсон усыг ундны усанд хэрэглэх боломжтой болсон.

**Sensiblu** 2002 онд гэр бүлийн хүчирхийлэл урьдчилан сэргийлэх зорилготой гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод үзүүлэх үйлчилгээг багтаасан хөтөлбөрийг санаачилсан. Sensiblu нь нийгэмд чиглэсэн үйлдвэрлэлийг дэмждэг ба үүнийгээ худалдан авалтын шалгуур үзүүлэлт болгодог бөгөөд технологийн шинэчлэл хийгдсэний дараа үлдсэн бүх компьютероо сургуулиуд, түнш байгууллагуудад хандивласан. Ингэснээр тус нийгэмлэгүүдийн технологийн хүрэлцээ сайжирч бараа бүтээгдэхүүний амьдралын мөчлөг уртасдаг. Эрүүл мэнд бол

Sensiblu-ийн нийгэмд чиглэсэн гол үйл ажиллагаа бөгөөд иймээс асрамжийн газар, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, явуулын эмчилгээний төвүүдийг санал болгодог ТББ-т их хэмжээний хөрөнгө оруулалт хийсэн.

**Romanel Harwood** үйлдвэрийнхээ хөршүүдэд өвлийн түлш хандивлаж байна. Тус компаний хувьд заримдаа дуу чимээ гаргах, салхитай өдөр модны зомгол хийсэх зэргээр оршин суугчдад нөлөөлж буй асуудлыг шийдвэрлэхээр хотын захиргааны байшин, сүм зэрэг нийгмийн байгууллагуудад түлш санал болгож тус нийгэмлэгийн гишүүдийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр дэмжиж байна.







**“Ёс зүй гэдэг бол  
шинэ өрсөлдөөний  
дүрэм юм”**

*ПЕТЕР РОБИНСОН  
/Улс төрч/*



КОМПАНИЙН НИЙГМИЙН  
ХАРИУЦЛАГЫН ТАЛААРХ  
ЗАРИМ НЭГ ТАШАА  
ОЙЛГОЛТУУД

9





## КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ТАЛААРХ ЗАРИМ НЭГ ТАШАА ОЙЛГОЛТУУД

Сүүлийн жилүүдэд Монголын аж ахуйн нэгжүүдийн хувьд КНХ-ыг хэрэгжүүлэгч гэх нэр томъёог зар сурталчилгаандаа хэрэглэдэг болсон. Гэвч КНХ-ын талаарх мэдлэг, мэдээлэл дутмаг, буяны хандивын үйл ажиллагаатай адилтган үзэх, нөгөөтэйгүүр хувийн нэр хүндээ өсгөх ядмагхан санаа зэрэг нь цаашид нийгмийн хариуцлагаа зөвөөр хэрэгжүүлэхэд бэрхшээл болохуйц ойлголтуудын жишээг бид энэхүү гарын авлагадаа орууллаа.

**М**онголын томоохон компаниудын нэг хажуудаа Хүнсний чиглэлийн компани нээж, Монголд үйл ажиллагаа явуулж байгаа. Мэдээж том компаний брэндийн ачаар өнөөдрийг хүртэл нэр хүндтэй явж байгаа, мөн удирдлага нь нийгмийн сайн сайхны төлөө ялангуяа эмэгтэйчүүдийн төлөө олон ажлуудыг хийсэн тухайгаа сурталчлан ярьж байгаагаас нь дүгнэвэл үнэхээр КНХ-аа сайн хэрэгжүүлж байгаа

мэт харагдахаар. Харамсалтай нь тус компаний ажилтнууд ажилдаа тогтдоггүй. Хамгийн ихдээ 1 жил ажиллах ч эрүүл мэндээрээ бүрэн хохирдог. Шаардлага хангаагүй нөхцөлд ажилласнаас болж бөөр давсаг, ууц нурууны өвчтэй болдог. Учир нь ажлын байр нь “чөмөг царцаам” хүйтэн (ажилтнуудын тодорхойлсноор), энэ нөхцөлд илүү цагаар ажиллуулдаг хэдий ч нэмэгдэл цалин өгдөггүй. Амралтын эсвэл баярын үеэр шөнө орой ажиллуулсан ч цалин өгдөггүй. Нэмэгдлээ өгөхгүй төдийгүй дээрээс нь цалинг нь цагтаа өгдөггүй, зарим тохиолдолд цалингийнх нь оронд үлдэгдэл бүтээгдэхүүнээ шахаж өгөх төдийгүй нийгмийн даатгалыг нь цалингаас нь суутгаж авдаг ч бөглөж өгдөггүй, татварын байгууллагад их хэмжээний өртэй явж байх жишээтэй. Өөрөөр хэлбэл ажилчиддаа наад захын халамж анхаарал тавьдаггүйн нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлдэггүйн тод жишээ гэж дүгнэж болохоор байна.





**Б**арилгын томоохон бүтээн байгуулагч компаний жишээг танилцуулахад барьсан барилга, олсон ашгаараа нийгэмдээ хэдийнэ танигдсан. Харамсалтай нь хөдөлмөрийн аюулгүй байдал хангаагүйгээс болж нас барсан эсвэл тахир дутуу болсон ажилтаны тоо жил бүр өссөөр л байна. Гэсэн ч тэдгээр ажилтнууддаа гэрээт ажилтан байсан гэсэн шалтгаанаар нөхөн олговор олгодоггүй. Хуулийн байгууллагаар дамжуулан дарамтлуулаад л ямар нэг хариуцлага хүлээдэггүй. Нөгөөтэйгүүр барилгын ажлын явцад иргэдийн тав тухыг алдагдуулдаг. Явган хүний зам гаргадаггүй, явган хүний замгүйгээс болж машинд шүргүүлсэн тохиолдолд нөхөн төлбөр олгодоггүй, хүний амрах ёстой шөнө оройн цагаар барилгын ажлаа үргэлжлүүлдэг гэх зэрэг олон баримтыг дурьдаж болно. Хэдийгээр нийгэмдээ хувь нэмрээ оруулж байгаа тухайгаа эрчимтэйгээр сурталчилж байгаа ч, үнэндээ хамгийн наад

захын үүргээ биелүүлэхгүй байгаа нь тун харамсалтай.

**М**онголын томоохон газар тариалан эрхлэгч салбартаа нөлөө бүхий нэгэн компани нийгмийн сайн сайхны төлөө олон ажлыг хийснээ бүх хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилдаг. Харамсалтай нь тус компани газар тариалан эрхлэхдээ өндөр ургац богино хугацаанд өгдөг, химийн агууламж хэт өндөртэй бордоо ашиглаж, түргэн хугацаанд болцыг нь гүйцээн зах зээлд гаргаж ихээхэн ашиг олдог. Ихэнх хэрэглэгчдийн хувьд газар тариалангийн талаар тийм ч сайн ойлголтгүй учир үндэсний үйлдвэрлэл, эко бүтээгдэхүүн гэж авч хэрэглэх хэдий ч урт хугацаанд нь биед өөрчлөлт орохыг мэргэжлийн хүмүүс нь хэлдэг ч тэрхүү мэдээлэл нь газар авах нь бага байх жишээтэй.

Энэ мэт олон жишээг дурьдаж болохоор байна.





